



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/72/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1.Аудитын дүгнэлт.....	2
1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	2
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,807,934.00	86,433,466.00
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	2,470,700.00
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	2,470,700.00
4	Төгрөг	0.00	2,470,700.00
5	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	2,470,700.00
6	АВЛАГА	0.00	44,640,300.00
7	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	44,640,300.00
8	БАРАА МАТЕРИАЛ	8,807,934.00	39,322,466.00
9	Түүхий эд материал	5,914,084.00	35,720,526.00
10	Эм боох материал	5,914,084.00	35,720,526.00
11	Хангамжийн материал	2,893,850.00	3,601,940.00
12	Аж ахуйн материал	2,426,000.00	2,426,000.00
13	Хүнсний материал	467,850.00	1,175,940.00
14	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	689,008,570.29	678,587,692.23
15	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	689,008,570.29	678,587,692.23
16	Биет хөрөнгө	677,010,570.29	666,589,692.23
17	Барилга, байгууламж, орон сууц	592,502,909.49	592,502,909.49
18	Хуримтлагдсан элэгдэл	-57,063,493.92	-84,245,240.88
19	Авто-тээврийн хэрэгсэл	150,118,666.00	150,118,666.00
20	Хуримтлагдсан элэгдэл	-78,314,269.00	-82,793,672.44
21	Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,540,397.96	87,993,788.96
22	Хуримтлагдсан элэгдэл	-42,383,444.72	-44,728,587.90
23	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,937,871.44	113,937,871.44
24	Хуримтлагдсан элэгдэл	-47,328,066.96	-66,196,042.44
25	Бусад үндсэн хөрөнгө	244,500.00	244,500.00
26	Хуримтлагдсан элэгдэл	-244,500.00	-244,500.00
27	Биет бус хөрөнгө	11,998,000.00	11,998,000.00
28	Бусад биет бус хөрөнгө	11,998,000.00	11,998,000.00
29	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	697,816,504.29	765,021,158.23
30	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	697,816,504.29	765,021,158.23
31	Засгийн газрын хувь оролцоо	697,816,504.29	765,021,158.23
32	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,144,827.71	208,144,827.71
33	Хуримтлагдсан үр дүн	236,173,754.76	303,378,408.70
34	Өмнөх үеийн үр дүн	272,825,022.60	236,173,754.76
35	Тайлант үеийн үр дүн	-36,651,267.84	67,204,653.94
36	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	253,497,921.82	253,497,921.82
37	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	697,816,504.29	765,021,158.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	506,727,391.44	1,129,110,783.27
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,707,511.44	274,525,528.27
3	Нийтлэг татварын бус орлого	40,707,511.44	274,525,528.27
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,143,580.00	16,864,396.00

5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30,563,931.44	257,661,132.27
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	466,019,880.00	854,585,255.00
7	Улсын төвлөрсөн төсвөөс	365,696,300.00	418,349,300.00
8	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,696,300.00	418,349,300.00
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,253,800.00	344,095,400.00
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,253,800.00	299,455,100.00
11	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,885,800.00	62,190,000.00
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,885,800.00	62,190,000.00
13	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,183,980.00	29,950,555.00
14	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,183,980.00	29,950,555.00
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	543,378,659.28	1,061,906,129.33
16	УРСГАЛ ЗАРДАЛ	543,378,659.28	1,061,906,129.33
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,378,659.28	1,015,816,129.33
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,049,149.00	411,920,427.00
19	Үндсэн цалин	189,152,180.00	188,667,222.00
20	Нэмэгдэл	78,664,000.00	167,269,105.00
21	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	0.00
22	Урамшуулал	18,896,969.00	44,089,800.00
23	Гэрээт ажлын хөлс	0.00	11,894,300.00
24	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,318,800.00	44,294,300.00
25	Тэтгэврийн даатгал	27,668,800.00	31,170,100.00
26	Тэтгэмжийн даатгал	2,912,500.00	3,281,100.00
27	ҮОМШӨ-ний даатгал	2,330,000.00	2,624,800.00
28	Ажилгүйдлийн даатгал	582,500.00	656,200.00
29	Эрүүл мэндийн даатгал	5,825,000.00	6,562,100.00
30	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,977,200.00	60,527,500.00
31	Гэрэл, цахилгаан	2,749,500.00	3,217,833.00
32	Түлш, халаалт	57,114,700.00	57,222,167.00
33	Цэвэр, бохир ус	113,000.00	87,500.00
34	Хангамж, бараа материалын зардал	23,393,200.00	30,129,600.00
35	Бичиг хэрэг	2,787,560.00	2,884,600.00
36	Тээвэр, шатахуун	15,299,480.00	22,000,000.00
37	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00
38	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	484,440.00	779,300.00
39	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,514,920.00	3,158,900.00
40	Нормативт зардал	52,034,197.44	395,326,133.27
41	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,126,047.44	361,759,545.27
42	Хоол, хүнс	6,132,650.00	27,470,288.00
43	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,775,500.00	6,096,300.00

44	Эд хогшил, урсгал засварын зардал	1,485,100.00	7,790,300.00
45	Багаж, техник, хэрэгсэл	0.00	7,028,800.00
46	Урсгал засвар	1,485,100.00	761,500.00
47	Томилолт, зочны зардал	1,800,000.00	2,900,000.00
48	Дотоод албан томилолт	1,800,000.00	2,900,000.00
49	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,660,051.00	689,200.00
50	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,500,351.00	0.00
51	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
52	Даатгалын үйлчилгээ	99,700.00	0.00
53	Тээврийн хэрэгслийн татвар	810,000.00	0.00
54	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	439,200.00
55	Бараа үйлчилгээний бусад зардал	58,660,961.84	62,238,669.06
56	Бараа үйлчилгээний бусад зардал	8,001,300.00	9,364,400.00
57	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,659,661.84	52,874,269.06
58	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	46,090,000.00
59	Бусад урсгал шилжүүлэг	0.00	46,090,000.00
60	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	46,090,000.00
61	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-36,651,267.84	67,204,653.94
62	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-36,651,267.84	67,204,653.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,144,827.71	253,497,921.82	236,173,754.76	697,816,504.29
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,144,827.71	253,497,921.82	236,173,754.76	697,816,504.29
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,144,827.71	253,497,921.82	236,173,754.76	697,816,504.29
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	67,204,653.94	67,204,653.94
5	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	208,144,827.71	253,497,921.82	303,378,408.70	765,021,158.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	466,019,880.00	809,944,955.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	466,019,880.00	809,944,955.00
3	Улсын төвлөрсөн төсвөөс	365,696,300.00	418,349,300.00
4	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,696,300.00	418,349,300.00
5	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,253,800.00	299,455,100.00

Өлзийт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

6	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,253,800.00	299,455,100.00
7	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,885,800.00	62,190,000.00
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,885,800.00	62,190,000.00
9	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,183,980.00	29,950,555.00
10	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,183,980.00	29,950,555.00
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	466,019,880.00	781,885,260.00
12	УРСГАЛ ЗАРДАЛ	466,019,880.00	781,885,260.00
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,960,180.00	735,795,260.00
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,032,000.00	411,920,427.00
15	Үндсэн цалин	189,135,031.00	188,401,515.00
16	Нэмэгдэл	78,664,000.00	172,212,612.00
17	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	0.00
18	Урамшуулал	18,896,969.00	39,412,000.00
19	Гэрээт ажлын хөлс	0.00	11,894,300.00
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,318,800.00	44,294,300.00
21	Тэтгэврийн даатгал	27,668,800.00	31,170,100.00
22	Тэтгэмжийн даатгал	2,912,500.00	3,281,100.00
23	ҮОМШӨ-ний даатгал	2,330,000.00	2,624,800.00
24	Ажилгүйдлийн даатгал	582,500.00	656,200.00
25	Эрүүл мэндийн даатгал	5,825,000.00	6,562,100.00
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,035,700.00	60,590,000.00
27	Гэрэл, цахилгаан	2,900,000.00	3,100,000.00
28	Түлш, халаалт	57,022,700.00	57,340,000.00
29	Цэвэр, бохир ус	113,000.00	150,000.00
30	Хангамж, бараа материалын зардал	20,430,280.00	30,956,800.00
31	Бичиг хэрэг	2,844,000.00	2,600,000.00
32	Тээвэр, шатахуун	14,229,480.00	22,000,000.00
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	1,500,000.00
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,550,000.00	3,550,000.00
36	Нормативт зардал	28,234,000.00	169,375,733.00
37	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,144,000.00	133,426,660.00
38	Хоол, хүнс	6,590,000.00	28,449,073.00
39	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	7,500,000.00
40	Эд хогшил, урсгал засварын зардал	1,450,100.00	7,568,800.00
41	Багаж, техник, хэрэгсэл	0.00	5,968,800.00
42	Урсгал засвар	1,450,100.00	1,600,000.00
43	Томилот, зочны зардал	1,800,000.00	2,900,000.00
44	Дотоод албан томилот	1,800,000.00	2,900,000.00
45	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,600,000.00	689,200.00
46	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,500,000.00	0.00
47	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
48	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
49	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	0.00
50	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	439,200.00

51	Бараа үйлчилгээний бусад зардал	8,059,300.00	7,500,000.00
52	Бараа үйлчилгээний бусад зардал	8,059,300.00	7,500,000.00
53	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,700.00	46,090,000.00
54	Бусад урсгал шилжүүлэг	0.00	46,090,000.00
55	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	46,090,000.00
56	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	59,700.00	0.00
57	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	59,700.00	0.00
58	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	28,059,695.00
59	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	25,588,995.00
60	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	25,588,995.00
61	Дотоод эх үүсвэрээр	0.00	25,588,995.00
62	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	25,588,995.00
63	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-25,588,995.00
64	Бусад зардал	0.00	0.00
65	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	2,470,700.00
66	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
67	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,470,700.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	515,747,400.00	510,489,855.00	5,257,545.00	98.98
2	УРСГАЛ ЗАРДАЛ	515,747,400.00	510,489,855.00	5,257,545.00	98.98
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,747,400.00	510,489,855.00	5,257,545.00	98.98
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	328,106,300.00	328,106,300.00	0.00	100.00
5	Үндсэн цалин	187,500,000.00	187,500,000.00	0.00	100.00
6	Нэмэгдэл	89,300,000.00	89,300,000.00	0.00	100.00
7	Урамшуулал	39,412,000.00	39,412,000.00	0.00	100.00
8	Гэрээт ажлын хөлс	11,894,300.00	11,894,300.00	0.00	100.00
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,294,300.00	44,294,300.00	0.00	100.00
10	Тэтгэврийн даатгал	31,170,100.00	31,170,100.00	0.00	100.00
11	Тэтгэмжийн даатгал	3,281,100.00	3,281,100.00	0.00	100.00
12	ҮОМШӨ-ний даатгал	2,624,800.00	2,624,800.00	0.00	100.00
13	Ажилгүйдлийн даатгал	656,200.00	656,200.00	0.00	100.00
14	Эрүүл мэндийн даатгал	6,562,100.00	6,562,100.00	0.00	100.00
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,590,000.00	60,590,000.00	0.00	100.00
16	Гэрэл, цахилгаан	3,100,000.00	3,100,000.00	0.00	100.00
17	Түлш, халаалт	57,340,000.00	57,340,000.00	0.00	100.00
18	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00	0.00	100.00
19	Хангамж, бараа материалын зардал	25,156,800.00	25,156,800.00	0.00	100.00

Өлзийт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

20	Бичиг хэрэг	2,300,000.00	2,300,000.00	0.00	100.00
21	Тээвэр, шатахуун	16,500,000.00	16,500,000.00	0.00	100.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00	0.00	100.00
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,550,000.00	3,550,000.00	0.00	100.00
25	Нормативт зардал	39,900,000.00	35,684,455.00	4,215,545.00	89.43
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,900,000.00	25,684,455.00	4,215,545.00	85.90
27	Хоол, хүнс	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.00
28	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
29	Эд хогшил, урсгал засварын зардал	5,100,000.00	4,568,800.00	531,200.00	89.58
30	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	2,968,800.00	531,200.00	84.82
31	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.00
32	Томилолт, зочны зардал	2,900,000.00	2,900,000.00	0.00	100.00
33	Дотоод албан томилолт	2,900,000.00	2,900,000.00	0.00	100.00
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	689,200.00	510,800.00	57.43
35	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
36	Даатгалын үйлчилгээ	80,000.00	0.00	80,000.00	0.00
37	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	0.00	120,000.00	0.00
38	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	439,200.00	310,800.00	58.56
39	Бараа үйлчилгээний бусад зардал	8,500,000.00	8,500,000.00	0.00	100.00
40	Бараа үйлчилгээний бусад зардал	8,500,000.00	8,500,000.00	0.00	100.00
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	515,747,400.00	510,489,855.00	5,257,545.00	98.98
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,349,300.00	418,349,300.00	0.00	100.00
43	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,349,300.00	418,349,300.00	0.00	100.00
44	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,190,000.00	62,190,000.00	0.00	100.00
45	Орон нутгийн төсвөөс	62,190,000.00	62,190,000.00	0.00	100.00
46	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,208,100.00	29,950,555.00	5,257,545.00	85.07
47	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,208,100.00	29,950,555.00	5,257,545.00	85.07
48	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	49	49		100.00
49	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.00
50	Төсвийн байгууллага	1	1		100.00
51	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24		100.00
52	Удирдах ажилтан	1	1		100.00
53	Гүйцэтгэх ажилтан	18	18		100.00
54	Үйлчлэх ажилтан	5	5		100.00
55	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	24		100.00
56	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	18		100.00
57	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6		100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	296,984,400.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	296,984,400.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,894,400.00
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,814,127.00
5	Үндсэн цалин	901,515.00
6	Нэмэгдэл	82,912,612.00
7	Хангамж, бараа материалын зардал	5,800,000.00
8	Бичиг хэрэг	300,000.00
9	Тээвэр, шатахуун	5,500,000.00
10	Нормативт зардал	151,280,273.00
11	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,331,200.00
12	Хоол, хүнс	20,949,073.00
13	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00
14	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00
15	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00
16	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,090,000.00
17	Бусад урсгал шилжүүлэг	46,090,000.00
18	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46,090,000.00
19	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	299,455,100.00
20	Нэмэлт санхүүжилтийн орлого	299,455,100.00
21	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	299,455,100.00
22	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	2,470,700.00
23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,470,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлзийт сумын ЭМТ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, хуульд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17 -ны өдрийн 8 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах”, 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх”, 4.2.1-д “хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх”, 4.2.2-д “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “*Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд цогцоор нь чанартай хүргэх*” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/585 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 515.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 64.7 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Мөнгө	-	2.5	2.5	100.0
Авлага	-	44.6	44.6	100.0
Бараа материал	8.8	39.3	30.5	346.6
Үндсэн хөрөнгө	689.0	678.6	(10.4)	(1.5)
Нийт хөрөнгө	697.8	765.0	64.7	9.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	697.8	765.0	67.2	9.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	697.8	765.0	67.2	9.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө 2.5 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

- Авлагын данс нь 44.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 44.6 сая төгрөг байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

- Бараа материалын үлдэгдэл 30.5 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын данс нь 8.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 197.7 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 257.7 сая төгрөг нийт 455.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 424.9 сая төгрөгийн зарцуулалт гарч, 39.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1.5 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 689.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 25.6 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 16.9 сая төгрөг нийт 42.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 52.9 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 678.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 67.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/эрүүл мэндийн даатгалын сангаас/	35.2	29.9	-5.3
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/	365.7	418.3	52.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	4.3	344.1	339.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10.1	16.9	6.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30.6	257.7	227.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсвөөс/	60.9	62.2	1.3
Үйл ажиллагааны орлого	506.8	1,129.1	622.3
Цалин, шимтгэлийн зардал	332.3	456.2	123.9
Бусад бараа үйлчилгээний зардал	211	559.6	348.6
Урсгал шилжүүлэг	0.06	46.1	46.04
Үйл ажиллагааны зардал	543.4	1,061.9	518.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-36.6	67.2	103.8

Өлзийт сумын ЭМТ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 52.6 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 339.8 сая төгрөгөөр өссөн нь ковид-19 холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч, дархлаажуулалт, пср, пср-ийн зөөвөр, урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн цогц үйлчилгээ авагч даатгуулагчийн тусламж үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 670.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 154.7 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 515.7 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 515.7 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг 98.9 хувь буюу 510.5 сая төгрөгийг авч, бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМГ-аас 33.6 сая төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сорьц тээвэрлэх зардалд 0.1 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид 19 цар тахалтай холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч болон дархлаажуулалтаар 265.7 сая төгрөг нийт 299.4 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд ковид 19 цар тахалтай холбоотой 475 даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, 24 иргэнд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэн, 5167 даатгуулагчид дархлаажуулах вакцины үйлчилгээг тус тус үзүүлсний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 265.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх журмын дагуу зарцуулан 2.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн ЭМГ-аас Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны А/496, А/585 тушаалын дагуу 24 албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 33.6 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Өлзийт сумын ЭМТ нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор давхардсан тоогоор 3513 иргэнд ПСР-ийн шинжилгээг, 10137 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг, 5167 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, 499 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг нийт 19316 иргэнд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 84.2 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 515.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор иргэнээс 10.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн материал хандиваар орж ирсэнг бүртгэл тайланд тусгасан байна.
2. Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн 24 иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд 22.0 сая төгрөгийн шатахуун, 10.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 1 жолоочтой, жолоочийн цалинд 13.4 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлзийт сумын ЭМТ нь 2021 онд нийт 142 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 134 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан бол 8 мэдээллийг хугацаа хоцроосон, 724.4 сая төгрөгийн 16 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дэх заалтуудыг хэрэгжүүлж, 2022 оны шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаад 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 129.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 123.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 1.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдал 3.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Үр дүнгийн тайлангийн нэмэгдэл урамшууллын зардлыг 4.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.

4.2 Албан шаардлага

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас 1.0 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн компьютер худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг дагаж мөрдөн ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 86 нэр төрлийн 123.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Өлзийт ЭМТ	Санхүүгийн Үр дүнгийн тайлангийн нэмэгдэл урамшууллын зардлыг 4.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.	1	4.9	1	4.9						
2		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 86 нэр төрлийн 123.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	123.8							1	123.8
3		Бараа үйлчилгээний бусад зардлаас 1.0 сая төгрөгийн өртөг бүхий Note-book худалдан авсан зөрчил илэрлээ.	1	1.0					1	1.0		
Дүн			3	129.7	1	4.9			1	1.0	1	123.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Өлзийт ЭМТ	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 8 мэдээлэл хугацаа хоцроосон, 724.4 сая төгрөгийн 16 мэдээллийг байршуулаагүй	1	724.4					1	724.4		
Дүн			1	724.4					1	724.4		
Нийт дүн			4	854.1	1	4.9			3	725.4	1	123.8